

## Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Холбооны нэрэмжит “Шилжин явах цом”-ын төлөөх спортын таван төрөлт тэмцээний удирдамж

Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Холбооны нэрэмжит “Шилжин явах цом”-ын төлөөх спортын таван төрөлт тэмцээнийг **2023 оны 1 дүгээр сарын 6, 7, 8-ны** өдрүүдэд зохион байгуулна.

Үүнд:

1. Шатар \эр,эм\
2. Зуун буудалт даам \эр,эм\
3. Ширээний теннис \эр,эм\
4. Сагсан бөмбөг \эр,эм\
5. Гар бөмбөг \эр, эм\

### Спортын тэмцээнд оролцох байгууллагууд:

Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Холбооны нэрэмжит шилжин явах цомын төлөөх тэмцээн нь зөвхөн МГФЗЗХолбооны гишүүн компаниуд, мэргэжлийн чиглэлээр ажиллаж буй гишүүн инженерүүдээс бүрдсэн багуудын хооронд нээлттэй зохиогдоно. *Жич: Бусад оролцох хүсэлтэй албан байгууллагууд хувьд МГФЗЗХолбооны дүрэмтэй танилцаж, [www.maqpc.mn](http://www.maqpc.mn) сайтад цахимаар бүртгүүлж гишүүнчлэлээр элсэн, татвараа төлсөн тохиолдолд нээлттэй.*

### Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүн:

- Шатрын тэмцээнд 1 эрэгтэй , 1 эмэгтэй, нийт 2 тамирчин
- Зуун буудалт даамны тэмцээнд 1 эрэгтэй, 1 эмэгтэй, нийт 2 тамирчин
- Ширээний теннисний тэмцээнд 1 эрэгтэй, 1 эмэгтэй, нийт 2 тамирчин
- Сагсан бөмбөгийн тэмцээнд эмэгтэй 1, эрэгтэй 1 баг орно. Баг тус бүр үндсэн 5, сэлгээний 2 хүртэл тамирчинтай байна.
- Гар бөмбөгийн тэмцээнд эмэгтэй 1, эрэгтэй 1 баг орно. Баг тус бүр үндсэн 6, сэлгээний 2 хүртэл тамирчинтай байна.

### Тэмцээний дүрэм:

#### 1. Шатар

Нийт эрэгтэй тамирчдын тоглолтыг тойргийн системээр тоглуулж, тамирчдын хамгийн өндөр оноо авсан байдлаар нь алт, мөнгө, хүрэл медалийн эздийг тодруулна.

Нийт эмэгтэй тамирчдын тоглолтыг тойргийн системээр тоглуулж, тамирчдын хамгийн өндөр оноо авсан байдлаар нь алт, мөнгө, хүрэл медалийн эздийг тодруулна.

Тэмцээнийг цагтай зохион байгуулах ба цагийн хуваарийг сугалаагаар бүсэд хуваагдсаны дараа тодорхой гаргана. 2 тоглогчийн хоорондох тоглолт ширээнд зэрэг эхэлж, цагийг зэрэг ажиллуулна. Тэмцээнийг нэг ерөнхий шүүгчтэй зохион байгуулна.

## **2. Зуун буудалт даам:**

Нийт эрэгтэй тамирчдын тоглолтыг тойргийн системээр тоглуулж, тамирчдын хамгийн өндөр оноо авсан байдлаар нь алт, мөнгө, хүрэл медалийн эздийг тодруулна.

Нийт эмэгтэй тамирчдын тоглолтыг тойргийн системээр тоглуулж, тамирчдын хамгийн өндөр оноо авсан байдлаар нь алт, мөнгө, хүрэл медалийн эздийг тодруулна.

Тэмцээнийг цагтай зохион байгуулах ба цагийн хуваарийг сугалаагаар бүсэд хуваагдсаны дараа тодорхой гаргана. 2 тоглогчийн хоорондох тоглолт ширээнд зэрэг эхэлж, цагийг зэрэг ажиллуулна. Тэмцээнийг нэг ерөнхий шүүгчтэй зохион байгуулна.

## **3. Ширээний теннис:**

Нийт тоглогчид 4 бүсэд сугалаагаар хуваан бүс бүрийн шилдэг 2 тоглогч бүсээс гарна. Бүсээс гарсан багуудыг 2 бүсэд хуваан тойргоор тоглож, бүс бүрээс шилдэг 2 тоглогч шалгаруулна. Шалгарсан 4 тоглогчид зөрж тоглоно. Зөрсөн тоглолтод хожсон 2 тоглогч алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 тоглогч хүрэл медалийн төлөө тоглоно. Тэмцээнийг нэг ерөнхий шүүгчтэй зохион байгуулна.

## **4. Сагсан бөмбөг:**

Эрэгтэй болон эмэгтэй сагсан бөмбөгийн баг 7 тамирчидтай байна. Нийт багуудыг 4 бүсэд сугалаагаар хуваан бүс бүрийн шилдэг 2 баг бүсээс гарна. Бүсээс гарсан багуудыг 2 бүсэд хуваан тойргоор тоглож, бүс бүрээс шилдэг 2 багийг шалгаруулна. Шалгарсан 4 багууд зөрж тоглоно. Зөрсөн тоглолтод хожсон 2 баг алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 баг хүрэл медалийн төлөө тоглоно. Тэмцээнийг ерөнхий шүүгч, талбайн 2 шүүгчтэй зохион байгуулна.

## **5. Гар бөмбөг:**

Эрэгтэй болон эмэгтэй гар бөмбөгийн баг 8 тамирчинтай байна. Нийт багуудыг 4 бүсэд сугалаагаар хуваан бүс бүрийн шилдэг 2 баг бүсээс гарна. Бүсээс гарсан багуудыг 2 бүсэд хуваан тойргоор тоглож, бүс бүрээс 2 шилдэг багийг шалгаруулна. Шалгарсан 4 баг зөрж тоглоно. Зөрсөн тоглолтод хожсон 2 баг алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 баг хүрэл медалийн төлөө тоглоно.

### **Байр, шагнал:**

- Спортын төрөл, оролцогч тус бүрээр :  
МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ, МӨНГӨН ШАГНАЛ (алт, мөнгө, хүрэл)
- Эрэгтэй, эмэгтэй шилдэг тоглогч (сагсан бөмбөг, гар бөмбөг)  
ӨРГӨМЖЛӨЛ, МӨНГӨН ШАГНАЛ
- Хөгжөөн дэмжигчдийн дундах тэмцээн  
МӨНГӨН ШАГНАЛ

### **Багийн дүнгээр шилжин явах цом гардуулна.**

Тэмцээнд сагсан бөмбөг болон гар бөмбөгөөр алт авсан багт 5 оноо, мөнгөн медаль авсан багт 4 оноо, хүрэл медаль авсан багт 3 оноо, 4-р байр эзэлсэн багт 2 оноо, харин шатар, даам, ширээний теннисээр алт авсан багт 4 оноо, мөнгөн медаль авсан багт 3 оноо, хүрэл медаль авсан багт 2 оноо, 4-р байр эзэлсэн багт 1 оноо өгч нийлбэр дүнгийн хамгийн ихээр “Шилжин явах цом”-

ын эзэн байгууллагыг шалгаруулж, цом мөнгөн шагналын хамт гардуулна. Оноо тэнцсэн тохиолдолд медалийн чанарыг харгалзана.

**Тэмцээн болох хугацаа, газар:**

№	Тэмцээний төрөл	Хугацаа	Газар
1	Шатар	2023.01.06-ний өдрийн 09.00 цагт	“Зууны шатар” шатрын клубт (Хүнсний 4-р дэлгүүр, АВ center 6 давхарт 606 тоот)
2	Зуун буудалт даам	2023.01.06-ний өдрийн 09.00 цагт	“Зууны шатар” шатрын клубт (Хүнсний 4-р дэлгүүр, АВ center 6 давхарт 606 тоот)
3	Ширээний теннис	2023.01.06-ны өдрийн 09.00 цагт	Оч ширээний теннисний клуб
4	Гар бөмбөг	2023.01.07-ны өдрийн 09.00 цагт	Чухаг спорт зааланд /Дүнжингарав урд талд/
5	Сагсан бөмбөг	2023.01.08-ны өдрийн 09.00 цагт	Чухаг спорт зааланд /Дүнжингарав урд талд/

**Тэмцээнд оролцох багуудад тавигдах шаардлага:**

1. Байгууллага спортын оролцох төрлөөс хамаарч дараах байдлаар хураамж төлнө . Үүнд:
  - Сагсан бөмбөг - 500 000 / эр, эм /
  - Гар бөмбөг - 500 000 / эр, эм /
  - Ширээний теннис - 80 000 /эр, эм /
  - Зуун буудалт даам - 80 000 /эр, эм /
  - Шатар - 80 000 /эр, эм / мянган төгрөг байна.
2. Нэг байгууллага спортын бүх төрөлд орсон тохиолдолд **800 000** төгрөгийн хураамж төлж болно.
3. Тэмцээний хураамжийг 2023 оны 01-р сарын 05-ны 14.00 цагаас өмнө **Хаан банкны 5175096762** / Монголын Геодези, Фотограмметр, Зураг зүйн Холбоо/ тоот дансанд хийнэ.
4. Компаниуд хоорондоо нэгдэн орж болно. Энэ тохиолдолд компаниуд нийлээд **900 000** төгрөгийн бооцооны хураамж төлнө. Мөн цомын төлөөх оноог хувааж тооцно.
5. Багууд нэгдсэн байдлаар өөрийн байгууллагын нэр, лого бүхий самбар, /Самбарын хэмжээ А3, хэвтээ байх/ тугтай байх;
6. Баг, тамирчдын мэдүүлэгт бичсэн нэр зөрсөн нь баримтаар баталгаажсан тохиолдолд тухайн тамирчин болон багийг тэмцээнээс шууд хасна.
7. Бичиг баримт болон бусад асуудлаар зөрчил гаргасан бол тухайн баг болон байгууллага өөрөө бүрэн хариуцах бөгөөд тэмцээнээс хасагдсан тохиолдолд бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.
8. Нийт оролцож байгаа багууд тэмцээнээ хүндэтгэн хувцаслалт жигд, хувийн дугаартай байх
9. Багийн сахилга бат, зохион байгуулалттай байх; (бусад багууд, хөгжөөн дэмжигч, шүүгчдийг хүндэтгэн, соёлтой боловсон харьцах)
10. Тоглолтын үед иргэний үнэмлэхээ авч явах бөгөөд тэмцээний үед зохион байгуулагчдад шалгуулах үүрэгтэй;
11. Багууд болон хөгжөөн дэмжигч нар зааланд заасан байрлалд байх (зохион байгуулагчаас

- байршил заалгаж авах);
12. Ширээний теннисний тэмцээнд оролцогчид өөрсдийн хувийн цохиуртайгаа ирэх;
  13. Тэмцээнд зарласан цагаас хоцрохгүй ирсэн байна. Тэмцээнд оролцох багуудын дарааллыг сугалаагаар тогтоох бөгөөд товлосон цагт тухайн тоглох баг байхгүй тохиолдолд шууд хожигдсонд тооцно.
  14. Тэмцээний нээлт, хаалтын арга хэмжээний үеэр тухайн байгууллагын багийн тамирчид бүрэн бүрэлдэхүүнээр бэлэн байна.

### **Мэдүүлэг хүлээн авах:**

Спортын төрөл тус бүрээр мэдүүлгийг багийн ахлагч [www.magpc.mn](http://www.magpc.mn) сайтын дээр үүсгэсэн Event-д 2023.01.04- ний дотор цахимаар мэдүүлнэ.

### **Тэмцээнд ирэхдээ анхаарах зүйлс:**

Үүнд:

- Багийн тамирчид бүр тус байгууллагад 2-аас доошгүй сар ажилласан, түүнийг нотлох нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа болон нийгмийн даатгалын тайлангийн НД-8 маягт, иргэний үнэмлэхийн хамт
- Бусад байгууллагад ажилладаг мэргэжлийн инженерүүд нэгдэн орж байгаа тохиолдолд дипломын хуулбар заавал авчрах
- Баг, тамирчдын тэмцээнд оролцох хураамж зэрэг болно.

### **Анхаарах зүйлс:**

- Хоол, ус, ундааны хаягдлыг зориулалтын хогийн саванд хаях
- Тамхийг зөвшөөрөгдсөн газарт татах
- Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэн ирэх, хэрэглэхийг хориглоно.
- Нийт тамирчид өөрийн солих хувцас, эд зүйлээ өөрөө хариуцна. Гээсэн, алдагдсан эд зүйлийг зохион байгуулагчид хариуцахгүй болно.

### **Техникийн зөвлөгөөн:**

Техникийн зөвлөгөөн 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 17.00 цагт **МГФ33Холбооны өрөөнд** болно. Баг тамирчдыг төлөөлөн 1-2 хүн цагтаа ирнэ үү.

МГФ33Холбооноос тэмцээнийг зохион явуулах техникийн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

Тэмцээний явцад гарсан маргаантай асуудлыг тухай бүрд нь техникийн зөвлөл ерөнхий шүүгчтэй хамтран шийдвэрлэнэ.

Шаардлагатай мэдээллийг 99042160, 88010889 утсаар авч болно.